

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЗОРЧИХ ХҮРТЭЭМЖИЙГ  
НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 03-р сарын 28-ны өдөр

Дугаар 2024/01-07

Улаанбаатар хот

<b>1. Зураг төсөл боловсруулах үндэслэл</b>	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/50 дугаар тушаал
<b>2. Барилга байгууламжийн байршил</b>	- Нийслэлийн 9 дүүргүүдийн нийтийн эзэмшлийн гудамж талбай
<b>3. Зориулалт хүчин чадал</b>	- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих хүртээмжийг нэмэгдүүлэх <ul style="list-style-type: none"><li>• Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг – 1750м2</li><li>• Баянгол, Сонгинохайрхан дүүрэг – 1750м2</li><li>• Баянзүрх, Хан-Уул дүүрэг – 1750м2</li></ul>
<b>4. Төслийн иж бүрдэл</b>	Баримт бичиг иж бүрдэл: <ul style="list-style-type: none"><li>- Тайлбар бичиг</li><li>- Ажлын тоо хэмжээ</li><li>- Батлагдах /УБЗАА/</li></ul> Зураг төслийн иж бүрдэл: <ul style="list-style-type: none"><li>- Одоогийн байдал /фото зургаар баталгаажуулах/</li><li>- Хэмжилтын зураг</li><li>- Барилгын нэгдсэн төсөв /Магадлалын дүгнэлт/</li></ul>
<b>5. Зураг төсөл боловсруулах үе шат, хугацаа</b>	Ажлын зураг төсөв нэг үе шаттай: <ul style="list-style-type: none"><li>- Зураг төсөв боловсруулж, зөвшилцөж батлуулах</li><li>- Захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндсэлэл болгоно.</li></ul>
<b>6. Арчлалт хамгаалалт</b>	Гүйцэтгэсэн ажлыг баталгаат хугацаанд өөрийн хөрөнгөөр засвар, арчлалтыг тогтмол гүйцэтгэнэ.
<b>7. Зураг төслийн байгууллага</b>	Захирамжийн дагуу сонгон шалгаруулалтаар шалгарсан байгууллага
<b>8. Төслийн захиалагч</b>	- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
<b>9. Хийгдэх тохижилтын ажлууд</b>	Ашиглагч, захиалагчийн хамт газар дээр нь очиж үзэж холбогдох хүмүүстэй зөвшилцөж, төсөвт өртөг багтах хэмжээгээр ажлын зураг төсвийг боловсруулна.
<b>10. Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөл боловсруулахад ашиглах материал</b>	<u>Төсөл хөтөлбөрүүд:</u> <ul style="list-style-type: none"><li>-Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага;</li><li>-Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал</li></ul> <u>Хууль тогтоомжууд:</u> <ul style="list-style-type: none"><li>-Газрын тухай хууль</li><li>-Барилгын тухай хууль</li></ul>

	<p>Норм, нормативууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Барилгын инженер геологийн ажил /БНБД 11-03-01/</li> <li>-Барилгын геодезийн ажил /БНБД 11-08-06/</li> <li>-Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05</li> <li>-Барилгын бүтээц, ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хавсралтуудыг боловсруулах хэрэглэх дүрэм БНБД 981-10-02</li> <li>-Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм БНБД 81-94-12</li> <li>-Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм</li> <li>-Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12</li> <li>-Хот, тосгоны нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм /БД 40-302-13/</li> <li>-Хот суурины гудамж, зам төлөвлөлт /БНБД 32-01-04/</li> <li>-Бусад холбогдох норм, дүрэм;</li> </ul> <p><u>Стандартууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/;</li> <li>-Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага UCS 0901B:2020</li> <li>-Бусад холбогдох стандартууд</li> </ul>
<b>11. Онцгой нөхцөл</b>	<p><u>Ажилд тавигдах шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>-Тус ажилд ашиглах материалыг сонгохдоо орчин үеийн дэвшилтэд технологи нэвтрүүлсэн. Монгол Улсын стандартад нийцсэн материал байх.</li> <li>-Явган зам талбайн хөдөлгөөн орц гарцыг гол гудамж, замын хөдөлгөөнтэй уялдуулан төлөвлөх</li> <li>-Гүйцэтгэлийн ажил эхлэхээс өмнө захиалагч, авторт нарт мэдэгдэж ажлын хувиарыг танилцуулах.</li> <li>-Зураг төслийг эхлэхдээ талбайд судалгаа хийж фото зураг хавсаргах, дэвсгэр зурагт заавал газар доорх инженерийн шугам сүлжээний тодруулга хийлгэх.</li> </ul>
<b>12. Эдийн засгийн тооцоо, төсөв</b>	Төсвийг ESTIMATOR-PRO программ тооцож ирүүлэх.
<b>13. Бусад</b>	Ажлын үе шат бүрт нэг цэгээс фото зураг авч, далдлагдсан ажил бүр дээр акт бичиж, инженерээр баталгаажуулна.

**ХЯНАСАН:**

ДУГУЙН БА ЯВГАН ХҮНИЙ ЗАМ, ТОХИЖИЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

**БОЛОВСРУУЛСАН:**

ДУГУЙН БА ЯВГАН ХҮНИЙ ЗАМ, ТОХИЖИЛТЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.БИЛГҮҮН

Ү.САНЧИР